

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН  
ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН**

*Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

<b>Нэр дэвшигчийн товч танилцуулга</b>	
1	<b>Эцэг/эхийн нэр:</b> Нямдаваа <b>Нэр:</b> Монсор <b>Хүйс:</b> Эрэгтэй <b>Нэр дэвшүүлсэн байгууллага:</b> Монгол Улсын Засгийн газар /“Монголын менежментийн манлайлал форум” НҮТББ/
2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</b> Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн
<b>Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:</b> Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 26 дугаар зүйлд “21.6.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар ... эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.”, “21.7.Энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, “21.8.Энэ хуулийн 21.7-д заасны дагуу нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.  1/Монгол Улсын Засгийн газар /“Монголын менежментийн манлайлал форум” НҮТББ/-аас нэр дэвшүүлсэн <b>Нямдаваагийн Монсор</b> нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.  2/2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” тогтоолыг баталж, 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн <b>Ёндонпэрэнлэйн Баатарбилэгийг</b> томилсон.	

### **3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:**

-Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, itoim.mn, ikon.mn, 24tsag.mn, livetv.mn, eduur.mn, news.mn, newspress.mn, times.mn, tovch.mn, zarig.mn, Mgl 88.3 фм радио зэргээр 32 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

-Мэдээллийн дагуу 1 ажиглагч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж, баталгаажуулсан.

**4/2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14.00 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд, Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, С.Бямбацогт, Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар, Н.Энхболд нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.**

**5/Нэр дэвшигч Н.Монсор нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Ажлын хэсэг (Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Тэргүүн дэд дарга Д.Ганбат, Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн нар хүрэлцэн ирж) ажлын хэсгийн тайланг Тэргүүн дэд дарга Д.Ганбат танилцуулсан.**

**6/Нэр дэвшигч болон ажлын хэсгийн тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар, Н.Энхболд нар асуулт асууж, хариулт авсан.**

**Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд:** мэргэжлийн хувьд шаардлага хэрхэн хангаж байгаа, Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдвол нэн тэргүүнд хийх ажлын талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн:** Олон нийтийн радио, телевизийн үндсэн чиг үүргийг судалсан эсэх, юу хийхээр төлөвлөж байгаа, бүтцийн шинэчлэлийг хэрхэн хийх, цомхон, чадварлаг байлгах тал дээр санал, санаачилга бий эсэх талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар:** Үндэсний зөвлөл дээр асуудал байгаа, зөвлөл ажиллах чадамжгүй байгаа, Зөвлөлийн гишүүн олон нийтийг төлөөлж ажиллах ёстой талаар, Олон нийтийн радио, телевиз үүргээ хэр хэмжээнд биелүүлж байгаа талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд:** Үндэсний зөвлөлийн хамт олонтойгоо хэрхэн хамтарч ажиллах, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй байхад хэрхэн анхаарах, эдийн засаг, санхүүгийн боловсролыг хэрхэн олгох, ямар аргаар хүргэх талаар, ашиг сонирхлын зөрчил бий эсэх талаар асуулт асуулаа.

**7/Нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Г.Ганболд, Д.Сарангэрэл нар Монголын Үндэсний олон нийтийн радио,**

телевизийн чиг үүрэг болон тухайн байгууллага ямар үйл ажиллагаа явуулдаг, ямар онцлогтой талаар, Монголын Үндэсний Радиог тоон системд шилжүүлэх шаардлагатай, уран бүтээлчдийг бүх талаас нь дэмжих, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаас нь ажиллах ёстой. Тус байгууллагын Үндэсний зөвлөлийн талаар шүүмжлэл их гардаг, Үндэсний зөвлөлийн Хяналтын зөвлөлийн чиг үүргийг хянан үзэх, Үндэсний зөвлөл нь тус байгууллагын хөгжлийн бодлогыг тодорхойлох, төлөвлөгөөг батлах чиг үүрэгтэй байгууллага гэдгийг анхаарах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

**8/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ёндонпэрэнлэйн Баатарбилэг хааж үг хэлсэн.**

**Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ё.Баатарбилэг:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу уг асуудлаар анх удаа нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулагдлаа.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор "Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах чиг үүрэг бүхий" Ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Энэхүү ажлын хэсэг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, олон нийтийн радио, телевизийн бодлого, үйл ажиллагаа нь олон нийтийн эрх ашигт нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргах, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох, Төрийн аудитын байгууллагын тайланд үндэслэн Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн санхүүжилт, түүний зарцуулалттай танилцах, олон нийтийн радио, телевизийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах гэсэн үндсэн таван чиглэлээр ажиллаж, дүгнэлт, санал зөвлөмж гаргасан талаар дурдаад энэхүү дүгнэлт, санал зөвлөмжийн дагуу холбогдох байгууллагууд болон нэр дэвшигчид танилцаж, томилогдсон тохиолдолд анхаарч ажиллах.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын хоёр өдрийн дотор сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайланд сонсголын дүнд үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж, холбогдох бусад мэдээллийг хавсаргана, тухайн тайланг ажлын таван өдрийн дотор нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах зохицуулалттай. Сонсголын тайланг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж эцсийн шийдвэр гаргах болно гэдгийг танилцуулав.

3	<p><b>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь</b> <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 26 дугаар зүйлд "21.6.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар ... эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.", "21.7.Энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан</p>
---	--

	<p>гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, “21.8.Энэ хуулийн 21.7-д заасны дагуу нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонголт хийсний үндсэн дээр хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонголын үе шат, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-126 дугаар зүйлийг баримтлан Нэр дэвшигчийн сонголыг 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт зохион байгууллаа.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонголт оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонголт явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонголын тайланг гаргалаа.</p>
4	<p><b>Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.</b></p> <p>Монгол Улсын Засгийн газраас Олон нийтийн, радио телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд <b>Нямдаваагийн Монсорыг</b> дэвшүүлсэн бөгөөд:</p> <p><b>1/Нэр дэвшигч Олон нийтийн, радио телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдвол</b> сайн засаглалын бэхжүүлж ажиллах болно мөн санхүү эдийн засгийн боловсролын агуулгыг түлхүү оруулах бодлого дээр анхааран дэмжин ажиллах болно.</p> <p>Манай улсын хувьд мэдээлэл хурдацтай түгэх болсон XXI зуунд мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах мөн олон нийтийн эрх ашигт үйлчилдэг байх нь чухал юм. МҮОНРТ-ийн хувьд дараах ажилд бодлогын түвшинд нэг багийн зарчмаар ажиллах болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• МҮОНРТ-ийн бүтээмжийг нэмэгдүүлэх дижитал шилжилтийг амжилттай хийх ажилд бодлогын түвшинд дэмжиж ажиллах;</li> <li>• МҮОНРТ-ийн санхүү болон эдийн засгийн боловсролын контентыг бүх насныханд зориулж явуулах ажилд бодлогын түвшинд дэмжиж ажиллах;</li> <li>• МҮОНРТ-ийн сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх ажлыг дэмжиж ажиллах;</li> <li>• МҮОНРТ-ийн жилийн төсвийн төлөвлөлт болон болон гүйцэтгэлийн хяналтыг хуулийн дагуу хийж гүйцэтгэх;</li> <li>• ОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн журам болон журмын хяналтыг хуулийн хүрээнд боловсронгуй болгож ажиллана;</li> <li>• МҮОНРТ-ийн эрх зүйн байдал, төсөв, санхүү, удирдлагын хараат бус байдлыг бий болгоход чиглэсэн эрх зүйн орчны шинэчлэлд дэмжлэг үзүүлж ажиллана;</li> <li>• МҮОНРТ-ийн хүний нөөцийн бодлого төлөвлөлт, болон нийт хамт олны нийгмийн асуудлыг шийдэхэд чиглэсэн бодлогын баримт бичиг боловсруулах, мөрдүүлэх ажилд бодлогын түвшинд дэмжиж ажиллана;</li> <li>• Үндэсний зөвлөл МҮОНРТ-ийн хамт олны зөвлөгөөнийг зохион байгуулж цаашид зөвлөлийн бодлого, баримтлах зарчимд хамт олны санал, санаачилгыг тусгах арга хэмжээг авахад дэмжлэг үзүүлж ажиллахаа илэрхийлэв.</li> </ul>


**2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Н.Монсорыг ажлын хэсгийн тайлан, ирүүлсэн материал болон сонголын үр дүнд үндэслэн Олон нийтийн радио, телевизийн үндэсний гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.**

Төрийн байгуулалтын байнгын хорооноос 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонголоос “Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлд Засгийн газрыг төлөөлсөн нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохдоо МҮОНРТ-ийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч ажиллах, тус байгууллагад үүсээд буй үйл ажиллагааны болон санхүүгийн хямралыг богино хугацаанд даван туулах төлөвлөгөөг гаргаж, гүйцэтгэх удирдлагатай хамтран ажиллах, Үндэсний зөвлөлийн чиг үүрэг, хяналтын тогтолцоог тодорхой болгох зэрэгт анхаарч, эдгээр асуудлыг шийдвэрлэх мэдлэг, ур чадвартай нэр дэвшигчийг дэвшүүлж байх, Үндэсний зөвлөл тогтвортой, чадамжтай ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарч, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг судалж танилцуулах нь зүйтэй гэж үзлээ.

**СОНСГОЛ ДАРГАЛАГЧ:**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Ё.БААТАРБИЛЭГ**



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН  
ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН**

*Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

<b>Нэр дэвшигчийн товч танилцуулга</b>	
1	<b>Эцэг/эхийн нэр:</b> Жаргалсайхан <b>Нэр:</b> Золзаяа <b>Хүйс:</b> Эмэгтэй <b>Нэр дэвшүүлсэн байгууллага:</b> Монгол Улсын Засгийн газар /Монголын үндэсний маркетингийн холбоо/
2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</b> Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн
<b>Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:</b> Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 26 дугаар зүйлд “21.6.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар ... эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.”, “21.7.Энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, “21.8.Энэ хуулийн 21.7-д заасны дагуу нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.  1/Монгол Улсын Засгийн газар /Монголын үндэсний маркетингийн холбоо/-аас нэр дэвшүүлсэн <b>Жаргалсайханы Золзаяа</b> нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.  2/2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” тогтоолыг баталж, 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн <b>Ёндонпэрэнлэйн Баатарбилэгийг</b> томилсон.	

### **3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:**

-Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, itoim.mn, ikon.mn, 24tsag.mn, livetv.mn, eguur.mn, news.mn, newspress.mn, times.mn, tovch.mn, zarig.mn, Mgl 88.3 фм радио зэргээр 32 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

-Мэдээллийн дагуу 1 ажиглагч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж, баталгаажуулсан.

-2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Ажлын хэсгийн тайланг Байнгын хороонд ирүүлснийг гишүүдэд хүргүүлсэн болно.

4/2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14.00 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд, Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, С.Бямбацогт, Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар, Н.Энхболд нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

5/Нэр дэвшигч Ж.Золзаяа нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Ажлын хэсэг (Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Тэргүүн дэд дарга Д.Ганбат, Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн нар хүрэлцэн ирж) ажлын хэсгийн тайланг Тэргүүн дэд дарга Д.Ганбат танилцуулсан.

6/Нэр дэвшигч болон ажлын хэсгийн тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар, Н.Энхболд нар асуулт асууж, хариулт авсан.

**Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд:** мэргэжлийн хувьд шаардлага хэрхэн хангаж байгаа, Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдвол нэн тэргүүнд хийх ажлын талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн:** Олон нийтийн радио, телевизийн үндсэн чиг үүргийг судалсан эсэх, юу хийхээр төлөвлөж байгаа, бүтцийн шинэчлэлийг хэрхэн хийх, цомхон, чадварлаг байлгах тал дээр санал, санаачлага бий эсэх талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар:** Үндэсний зөвлөл дээр асуудал байгаа, зөвлөл ажиллах чадамжгүй байгаа, Зөвлөлийн гишүүн олон нийтийг төлөөлж ажиллах ёстой талаар, Олон нийтийн радио, телевиз үүргээ хэр хэмжээнд биелүүлж байгаа талаар, хэрхэн цомхон, чадварлаг байлгах тал дээр тодорхой санал, санаачилга бий эсэх талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд:** Үндэсний зөвлөлийн хамт олонтойгоо хэрхэн хамтарч ажиллах, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаагаа олон нийтэд

нээлттэй байхад хэрхэн анхаарах, эдийн засаг, санхүүгийн боловсролыг хэрхэн олгох, ямар аргаар хүргэх талаар, ашиг сонирхлын зөрчил бий эсэх талаар асуулт асуулаа.

7/Нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Г.Ганболд, Д.Сарангэрэл нар Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн чиг үүрэг болон тухайн байгууллага ямар үйл ажиллагаа явуулдаг, ямар онцлогтой талаар, Монголын Үндэсний Радиоог тоон системд шилжүүлэх шаардлагатай, уран бүтээлчдийг бүх талаас нь дэмжих, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаас нь ажиллах ёстой. Тус байгууллагын Үндэсний зөвлөлийн талаар шүүмжлэл их гардаг, Үндэсний зөвлөлийн Хяналтын зөвлөлийн чиг үүргийг хянан үзэх, Үндэсний зөвлөл нь тус байгууллагын хөгжлийн бодлогыг тодорхойлох, төлөвлөгөөг батлах чиг үүрэгтэй байгууллага гэдгийг анхаарах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

8/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ёндонпэрэнлэйн Баатарбилэг хааж үг хэлсэн.

**Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ё.Баатарбилэг:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу уг асуудлаар анх удаа нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулагдлаа.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор "Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах чиг үүрэг бүхий" Ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Энэхүү ажлын хэсэг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, олон нийтийн радио, телевизийн бодлого, үйл ажиллагаа нь олон нийтийн эрх ашигт нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргах, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох, Төрийн аудитын байгууллагын тайланд үндэслэн Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн санхүүжилт, түүний зарцуулалттай танилцах, олон нийтийн радио, телевизийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах гэсэн үндсэн таван чиглэлээр ажиллаж, дүгнэлт, санал зөвлөмж гаргасан талаар дурдаад энэхүү дүгнэлт, санал зөвлөмжийн дагуу холбогдох байгууллагууд болон нэр дэвшигчид танилцаж, томилогдсон тохиолдолд анхаарч ажиллах.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын хоёр өдрийн дотор сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайланд сонсголын дүнд үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж, холбогдох бусад мэдээллийг хавсаргана, тухайн тайланг ажлын таван өдрийн дотор нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах зохицуулалттай. Сонсголын тайланг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж эцсийн шийдвэр гаргах болно гэдгийг танилцуулав.

3	<b>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь</b> <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i>
---	--

	<p>Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 26 дугаар зүйлд “21.6.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар ... эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.”, “21.7.Энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, “21.8.Энэ хуулийн 21.7-д заасны дагуу нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонсголын үе шат, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-126 дугаар зүйлийг баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт зохион байгууллаа.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.</p>
4	<p><b>Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.</b></p> <p>Монгол Улсын Засгийн газраас Олон нийтийн, радио телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд <b>Жаргалсайханы Золзаяаг</b> дэвшүүлсэн бөгөөд:</p> <p><b>1/Нэр дэвшигч Олон нийтийн, радио телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдвол иргэдийн төлөөлөл байж, стратеги төлөвлөгөө, зорилго зорилтыг улам сайжруулж, инновац, технологийн чиглэлийн агуулга бүхий бодлого дээр дэмжин ажиллах болно.</b></p> <p>Мөн дараах ажил дээр бодлогын түвшинд эв нэгдэл, хүний эрх, олон талт хамтын ажиллагаа, хараат бус байдлыг дээдлэн ажиллана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• МҮОНРТ-ийн менежментийг сайжруулах, сайн засаглалыг хэрэгжүүлэх ажлыг дэмжиж ажиллана;</li> <li>• Дэлхий даяар технологийн хөгжил асар хурдацтай хөгжиж буй энэ цаг үед мэдээллийн хүртээмжийг сайжруулж, дижитал шилжилтийг амжилттай хийхэд дэмжин ажиллана;</li> <li>• МҮОНРТ-ийн нийт хамт олон уран бүтээлчдийн нийгмийн асуудлыг шийдэхэд чиглэсэн бодлогын ажилд дэмжин ажиллахаас гадна бүтээмжийг дээшлүүлэх, хувь хүний хөгжилд орчин үеийн арга зүйд үндэслэсэн ажил хийхэд бодлогын түвшинд дэмжин ажиллана;</li> <li>• МҮОНРТ-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хуулийн дагуу батлахад дэмжин ажиллана;</li> <li>• МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн журам болон журмын хяналтыг хуулийн хүрээнд боловсронгуй болгож ажиллана;</li> <li>• МҮОНРТ-ийн инновац, технологи, гарааны бизнес эрхлэх чиглэлийн контентыг бүтээлч сонирхолтой байдлаар хийх ажил дээр бодлогын түвшинд ажиллана;</li> </ul>

- МҮОНРТ-ийн хүүхдийн мэргэжил сонголтод чиглэсэн агуулга бүхий танин мэдэхүйн контентийг хийхэд бодлогын түвшинд дэмжин ажиллана;
- МҮОНРТ-ийн хөтөлбөрт олон нийтэд урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх контент хийхэд бодлогын түвшинд дэмжин ажиллана.

**2/Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Ж.Золзаяаг ажлын хэсгийн тайлан, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Олон нийтийн радио, телевизийн үндэсний гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.**

Төрийн байгуулалтын байнгын хорооноос 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголоос "Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлд Засгийн газрыг төлөөлсөн нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохдоо МҮОНРТ-ийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч ажиллах, тус байгууллагад үүсээд буй үйл ажиллагааны болон санхүүгийн хямралыг богино хугацаанд даван туулах төлөвлөгөөг гаргаж, гүйцэтгэх удирдлагатай хамтран ажиллах, Үндэсний зөвлөлийн чиг үүрэг, хяналтын тогтолцоог тодорхой болгох зэрэгт анхаарч, эдгээр асуудлыг шийдвэрлэх мэдлэг, ур чадвартай нэр дэвшигчийг дэвшүүлж байх, Үндэсний зөвлөл тогтвортой, чадамжтай ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарч, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг судалж танилцуулах нь зүйтэй гэж үзлээ.

**СОНСГОЛ ДАРГАЛАГЧ:**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Ё.БААТАРБИЛЭГ**

